

# ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Радио телевизийн үндэсний сүлжээ УТҮГ-ийн 2025 оны санхүүгийн  
тайланд хийсэн аудитын тайлан

Аудитын код: САГ-2026/58/НА-СТА-ТӨҮГ

Цахим  
хуудас: [www.audit.mn](http://www.audit.mn)  
Улаанбаатар хот  
2026 он

Санхүүгийн аудитын газрын захирал,  
тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг  
Утас: 261665 Цахим  
хаяг: [naranchimegts@audit.gov.mn](mailto:naranchimegts@audit.gov.mn)  
Аудитын менежер А.Цогбаяр  
Утас: 261628 Цахим хаяг: [tsogbayara@audit.gov.mn](mailto:tsogbayara@audit.gov.mn)  
Аудитор Д.Номингуя  
Утас: 261628 Цахим хаяг: [nominguad@audit.gov.mn](mailto:nominguad@audit.gov.mn)  
“Ажу мэргэн аудит” ХХК-ийн захирал Л.Насанбуян  
Утас: 99093142 Цахим  
хаяг: [Ajumergenaudit.mon@gmail.com](mailto:Ajumergenaudit.mon@gmail.com)

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

---

1. ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ .....	4
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан .....	7
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан .....	9
2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан .....	11
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан .....	12
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан .....	14
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА .....	16
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа .....	16
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин .....	16
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал .....	16
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого ба толилуулгад орсон өөрчлөлт .....	17
3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв .....	18
3.6 Худалдан авах ажиллагаа .....	19
4. АУДИТЫН ТАЙЛАН .....	20
4.1 Ерөнхий зүйл .....	20
4.2 Материаллаг байдал .....	20
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт .....	20
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал .....	20
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт .....	21
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт .....	21
4.5.1 Завсрын аудитын талаар .....	21
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал .....	22
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ .....	22
5.1 Төлбөрийн акт .....	22
5.2 Албан шаардлага .....	22
5.3 Зөвлөмж .....	24
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ .....	25

**Товчилсон үгийн жагсаалт**

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
РНТС	Радио нэвтрүүлэх төв станц
СТОУС	Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
УТҮГ	Улсын төсөвт үйлдвэрийн газар
ЦХИХХЯ	Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яам



## ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

Засгийн газрын IV байр, Бага тойруу 3,  
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15160  
Утас: 26 04 37, Факс: (976-51) 26 42 30,  
Цахим шуудан: info@audit.gov.mn,  
Цахим хуудас: www.audit.mn

РАДИО ТЕЛЕВИЗИЙН ҮНДЭСНИЙ  
СҮЛЖЭЭ УТУГ-ЫН ЗАХИРАЛ  
Ц.ПҮРЭВНЯМ ТАНАА

2026.03.16 № 06/664  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

### Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, 8.4, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Радио телевизийн үндэсний сүлжээ УТУГ-ийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл хэсэгт тайлбарласан зүйлсийн үр нөлөөг эс тооцвол 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээг бүх материаллаг талаар нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу бүхий л материаллаг байдлын үүднээс үнэн зөв толилуулсан байна.

### Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайлангийн аудитаар нийт 287.2 сая төгрөгийн зөрчил илэрсэн нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс давсан бөгөөд дангаараа болон нийт дүнгээрээ санхүүгийн тайланд материаллаг нөлөөтэй боловч өргөн тархаагүй байна. Тухайлбал:

- Анхан шатны бүрдэл дутуу баримтаар нийт 118.2 сая төгрөгийн хөрөнгийн худалдан авалт хийж, өмнөх оны аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлээгүй.
- Тайлант оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдаагүй нийт 77.6 сая төгрөгийн үндсэн хөрөнгийг бартерын хэлбэрээр худалдаж авсан.
- Өмнөх онуудад үүссэн нийт 12.1 сая төгрөгийн авлагыг барагдуулах арга хэмжээ аваагүй.

Эдгээр зөрчлүүд нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.1, 16.5.2, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.1, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1, 13.4, 13.7, 20 дугаар зүйлийн 20.2.5, Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.6, 15 дугаар зүйлийн 15.1.3 заалттай тус тус нийцээгүй бөгөөд санхүүгийн

тайлагналын "эрх ба үүрэг", "нийцсэн бөгөөд зохистой байх" батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

### **Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг**

Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2026 оны 01 дүгээр сарын 06-ны өдрийн А/22 дугаар албан бичгээр өгсөн зөвшөөрлийн дагуу үндсэн хөрөнгийн дансанд бүртгэлтэй 8.5 сая төгрөгийн үнэ бүхий 6.2 сая төгрөгийн хуримтлагдсан элэгдэлтэй хөрөнгийг харьяа байгууллагуудад үнэ төлбөргүй шилжүүлж, мөн 2025 оны 898 дугаар тогтоолын дагуу 142.0 сая төгрөгийн үндсэн хөрөнгийг акталж данс бүртгэлээс хасалт хийсэн.

### **Аудитын гол асуудал**

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Радио телевизийн үндэсний сүлжээ УТҮГ-ын захирлын 2025 оны 03 дугаар сарын 21-ний өдрийн А/12 тушаалаар "Үйлчилгээний үнэ тариф"-ыг шинэчлэн баталсан байна.

### **Бусад асуудал**

Эрчим хүчний үнийн өсөлтийг бууруулах, одоогийн хэрэглэж байгаа нүүрсний хэрэглээг багасгах, агаарын бохирдлыг бууруулах зорилгоор Хонгорын радио нэвтрүүлэх төв станц дээр 1.5 МВт-ын хүчин чадалтай нарны батарейн сэргээгдэж эрчим хүчний станц барих "Утаагүй зуухны төсөл"-ийг хэрэгжүүлэх судалгаа, туршилтын ажлыг мэргэжлийн байгууллагууд болон агаарын бохирдлыг бууруулах Үндэсний хорооны мэргэжилтнүүдтэй хамтран ажилласан байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

### **Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

### **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН  
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР *Ц. Наранчимэг* Ц.НАРАНЧИМЭГ



## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Дансны нэр, төрөл	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	2,084,550,967.71	1,956,638,981.46
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	48,766,417.57	24,798,357.69
311	Кассанд байгаа бэлэн мөнгө	3,058,557.73	1,114,554.73
31110	Төгрөг	3,058,557.73	1,114,554.73
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	45,707,859.84	23,683,802.96
3121	Төгрөг	45,664,456.87	23,641,407.57
31211	Төрийн сангийн харилцах	237,699.43	13,246.77
31213	Арилжааны банк дахь харилцах	45,426,757.44	23,628,160.80
3122	Гадаад валют	43,402.97	42,395.39
31223	Арилжааны банк дахь харилцах	43,402.97	42,395.39
33	АВЛАГА	85,474,496.12	88,033,796.12
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	1,100,000.12	1,120,000.12
33200	Төлбөртэй үйлчилгээний авлага	72,449,346.00	62,886,069.00
335	Бусад авлага	11,925,150.00	24,027,727.00
3351	Байгууллагаас авах авлага	-	24,027,727.00
3352	Хувь хүмүүсээс авах авлага	11,925,150.00	-
34	УРЬДЧИЛГАА	450,000.00	1,521,000.00
34713	Цалингийн урьдчилгаа	-	1,071,000.00
34714	Томилолтын урьдчилгаа	450,000.00	450,000.00
35	БАРАА МАТЕРИАЛ	1,949,860,054.02	1,842,285,827.65
354	Хангамжийн материал	1,949,860,054.02	1,842,285,827.65
35410	Бичиг хэргийн материал	14,963,436.00	8,475,786.00
35420	Аж ахуйн материал	30,855,591.86	21,436,393.99
35430	Сэлбэг хэрэгсэл	1,667,068,628.10	1,614,187,697.50
35440	ТҮлш, шатах тослох материал	18,918,156.06	10,935,443.56
35470	Бусад хангамжийн материал	218,054,242.00	187,250,506.60
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	76,638,707,917.20	75,190,941,377.64
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	76,638,707,917.20	75,190,941,377.64
392	Биет хөрөнгө	9,465,540,469.44	8,038,619,310.88
39201	Барилга, байгууламж, орон сууц	5,703,936,521.85	5,703,936,521.85
39202	Хуримтлагдсан элэгдэл	(1,454,561,433.86)	(1,757,682,197.57)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	503,570,621.09	503,570,621.09
39204	Хуримтлагдсан элэгдэл	(445,686,831.77)	(472,977,018.11)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	16,394,465,353.32	16,396,943,929.17
39206	Хуримтлагдсан элэгдэл	(11,308,860,518.47)	(12,391,920,928.89)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	212,842,777.20	205,006,789.65
39208	Хуримтлагдсан элэгдэл	(145,458,716.17)	(152,892,557.56)
39209	Зам, гүүрийн байгууламж	37,854,750.00	37,854,750.00
39210	Хуримтлагдсан элэгдэл	(37,854,750.00)	(37,854,750.00)
39214	Бусад үндсэн хөрөнгө	41,503,422.00	41,503,422.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	(36,210,725.75)	(36,869,270.75)
393	Биет бус хөрөнгө	67,173,167,447.76	67,152,322,066.76
39301	Програм хангамж	40,892,144.00	40,892,144.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(21,050,096.08)	(40,135,477.24)
39303	Бусад биет бус хөрөнгө	67,161,135,400.00	67,161,135,400.00

Радио телевизийн үндэсний сүлжээ УТҮГ-ын 2025 оны санхүүгийн  
тайланд хийсэн аудитын тайлан

39304	Хуримтлагдсан элэгдэл	(7,810,000.16)	(9,570,000.00)
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	78,723,258,884.91	77,147,580,359.10
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	10,496,779.79	2,105,865,147.01
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	10,496,779.79	2,105,865,147.01
413	Өглөг	10,496,779.79	2,105,865,147.01
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	2,296,779.79	93,870,277.92
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	-	1,940,240,647.09
4136	Бусад өглөг	8,200,000.00	71,754,222.00
41361	Байгууллагад төлөх өглөг	8,200,000.00	71,754,222.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	78,712,762,105.12	75,041,715,212.09
51	Засгийн газрын хувь оролцоо	86,576,701,133.39	85,105,213,164.84
51101	Өмч /төрийн/	80,210,908,069.87	80,210,908,069.87
512	Хуримтлагдсан үр дүн	(7,863,939,028.27)	(10,063,497,952.75)
51210	Өмнөх үеийн үр дүн	(7,863,939,028.27)	(6,388,829,581.40)
51220	Тайлант үеийн үр дүн	-	(3,674,668,371.35)
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	6,365,793,063.52	4,894,305,094.97
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	78,723,258,884.91	77,147,580,359.10

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Дансны нэр, төрөл	Өмнөх он	Тайлант он
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН	7,494,042,972.53	6,551,409,170.25
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	1,059,846,772.53	6,551,409,170.25
120	Нийтлэг татварын бус орлого	1,059,846,772.53	1,331,409,170.25
1201	Хүүгийн орлого	2,361,581.77	2,005,112.44
120002	Бусад хүүгийн орлого	2,361,581.77	2,005,112.44
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	956,693,338.06	1,195,502,202.13
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	237,576,284.25	237,199,987.35
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	719,117,053.81	958,302,214.78
120009	Бусад орлого	84,977,779.16	91,413,893.68
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	14,730,021.54	40,988,640.00
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал	1,084,052.00	1,499,322.00
122	Тусламжийн орлого	0	5,220,000,000.00
1221	Хандив тусламж /дотоод/	0	5,220,000,000.00
12211	Харъяа төрийн сангаас төсвийн байгууллагад олгосон санхүүжилт, шилжүүлгийн орлого	0	5,220,000,000.00
122111	Урсгал санхүүжилтийн орлого	0	5,220,000,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	6,434,196,200.00	0
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	6,434,196,200.00	0
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	6,434,196,200.00	0
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	10,248,944,972.70	10,225,867,118.24
21	УРСГАЛ ЗАРДАЛ	10,248,944,972.70	10,225,867,118.24
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	10,017,204,308.70	10,058,093,115.24
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	3,596,006,984.19	4,278,791,277.25
210101	Үндсэн цалин	3,596,006,984.19	4,254,696,561.25
210102	Нэмэгдэл	0	6,016,315.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	0	1,694,000.00
210104	Урамшуулал	0	4,411,500.00
210105	Гэрээт ажлын хөлс	0	11,972,901.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	438,097,806.10	522,407,676.53
210201	Тэтгэврийн даатгалын зардал	297,724,149.44	368,244,361.28
210202	Тэтгэмжийн даатгалын зардал	35,464,203.49	38,666,701.38
210203	ҮОМШӨ-ний даатгалын зардал	20,574,027.62	20,399,292.29
210204	Ажилгүйдлийн даатгалын зардал	14,461,386.35	17,892,492.17
210205	Эрүүл мэндийн даатгалын зардал	69,874,039.20	77,204,829.41
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	1,756,087,501.02	2,524,389,251.24
210301	Гэрэл, цахилгаан	1,625,884,501.52	2,345,459,766.24
210302	Түлш, халаалт	101,893,232.50	127,422,494.50
210303	Цэвэр, бохир ус	25,975,367.00	51,094,590.50
210304	Байрны түрээс	2,334,400.00	412,400.00
2104	Хангамж, бараа материалын зардал	179,148,920.52	174,564,722.88

Радио телевизийн үндэсний сүлжээ УТҮГ-ын 2025 оны санхүүгийн  
тайланд хийсэн аудитын тайлан

210401	Бичиг хэрэг	15,871,470.00	11,805,002.00
210402	Тээвэр, шатахуун	99,904,399.00	80,015,958.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	28,083,976.83	33,481,173.61
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	3,964,488.89	1,200,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	28,807,185.80	23,993,136.39
210407	Аж ахуйн материал худалдан авах зардал	2,517,400.00	4,079,020.48
210408	Бараа материал акталсны зардал	0	19,990,432.40
2105	Нормативт зардал	27,999,600.00	21,321,374.86
210502	Хоол, хүнс	0	3,567,374.86
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	27,999,600.00	17,754,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	520,269,098.07	315,009,179.55
210601	Багаж, техник, хэрэгсэл	11,731,978.00	9,533,493.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	20,356,350.00	10,177,854.00
210604	Урсгал засвар	488,180,770.07	295,297,832.55
2107	Томилолт, зочны зардал	103,024,349.10	63,416,736.00
210701	Гадаад албан томилолт	27,928,829.10	0
210702	Дотоод албан томилолт	75,095,520.00	63,416,736.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	558,821,694.89	565,227,617.39
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	134,355,762.74	123,801,024.46
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	19,852,600.00	17,012,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	20,850,665.00	14,766,384.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	2,188,473.00	6,293,245.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	220,000.00	77,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	146,106,857.00	150,969,228.80
210807	Газрын төлбөр	234,355,105.00	251,331,259.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	892,232.15	977,476.13
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	2,837,748,354.81	1,592,965,279.54
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	14,900,000.00	4,420,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	2,822,848,354.81	1,588,545,279.54
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	231,740,664.00	167,774,003.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	231,740,664.00	167,774,003.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	29,178,330.00	31,104,000.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	0	79,036,301.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	66,622,467.00	56,843,702.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	135,939,867.00	790,000.00
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	-2,754,902,000.17	-3,674,457,947.99
IV	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН	0	1,932.59
145001	Гадаад валютын ханшийн зөрүүний олз	0	1,932.59
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	80,504.94	212,355.95
225004	Гадаад валютын ханшийн зөрүүний гарз	80,504.94	212,355.95
VII	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (VII)=(IV)-(V)	-80,504.94	-210,423.36
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(VII)	-2,754,982,505.11	-3,674,668,371.35

### 2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Дансны нэр, төрөл	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан үр дүн	Нийт дүн
3	2023 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	80,210,908,069.87	4,930,894,382.07	(5,109,485,355.76)	80,032,317,096.18
4	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	528,832.60	528,832.60
5	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	-	-	(5,108,956,523.16)	(5,108,956,523.16)
9	Тайлант үеийн үр дүн	-	-	(2,754,982,505.11)	(2,754,982,505.11)
10	2024 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	80,210,908,069.87	6,365,793,063.52	(7,863,939,028.27)	78,712,762,105.13
12	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	1,475,109,446.87	1,475,109,446.87
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	80,210,908,069.87	6,365,793,063.52	(6,388,829,581.40)	80,187,871,551.99
18	Тайлант үеийн үр дүн	-	-	(3,674,668,371.35)	(3,674,668,371.35)
19	2025 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	80,210,908,069.87	4,894,305,094.97	(10,063,497,952.75)	75,041,715,212.09

## 2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Дансны нэр, төрөл	Өмнөх он	Тайлант он
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН	7,406,326,368.00	6,387,620,654.30
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	972,130,168.00	6,387,620,654.30
120	Нийтлэг татварын бус орлого	972,130,168.00	1,179,548,354.30
1201	Хүүгийн орлого	2,361,581.76	2,005,112.44
120002	Бусад хүүгийн орлого	2,361,581.76	2,005,112.44
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	884,755,807.06	1,086,520,380.18
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	234,256,184.25	234,367,287.35
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	650,499,622.81	852,153,092.83
120009	Бусад орлого	85,012,779.18	91,022,861.68
122	Тусламжийн орлого	0	5,208,072,300.00
1221	Хандив тусламж /дотоод/	0	5,208,072,300.00
12211	Харъяа төрийн сангаас төсвийн байгууллагад олгосон санхүүжилт, шилжүүлгийн орлого	0	5,208,072,300.00
122111	Урсгал санхүүжилтийн орлого	0	5,208,072,300.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	6,434,196,200.00	0
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	6,434,196,200.00	0
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	6,434,196,200.00	0
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	7,383,336,346.94	6,411,378,290.82
21	УРСГАЛ ЗАРДАЛ	7,383,336,346.94	6,411,378,290.82
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	7,151,595,682.94	6,243,604,287.82
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	3,593,809,083.28	4,197,482,887.92
210101	Үндсэн цалин	3,558,872,183.28	4,185,509,986.92
210103	Унаа хоолны хөнгөлөлт	16,689,500.00	0
210105	Гэрээт ажлын хөлс	18,247,400.00	11,972,901.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	436,733,794.46	519,305,073.09
210201	Тэтгэврийн даатгалын зардал	296,796,614.31	351,519,812.54
210202	Тэтгэмжийн даатгалын зардал	35,355,083.12	42,231,713.38
210203	ҮОМШӨ-ний даатгалын зардал	20,510,481.19	22,068,982.30
210204	Ажилгүйдлийн даатгалын зардал	14,415,815.43	19,449,879.46
210205	Эрүүл мэндийн даатгалын зардал	69,655,800.41	84,034,685.41
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	1,753,160,546.52	573,646,258.65
210301	Гэрэл, цахилгаан	1,624,058,029.52	415,080,646.15
210302	Түлш, халаалт	100,792,750.00	117,407,994.00
210303	Цэвэр, бохир ус	25,975,367.00	40,745,218.50
210304	Байрны түрээс	2,334,400.00	412,400.00
2104	Хангамж, бараа материалын зардал	184,705,623.83	136,802,877.61
210401	Бичиг хэрэг	19,815,220.00	5,515,352.00
210402	Тээвэр, шатахуун	94,913,192.00	80,548,424.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	28,062,496.83	33,481,173.61
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	3,875,600.00	1,200,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	38,039,115.00	16,057,928.00
2105	Нормативт зардал	45,278,900.00	6,273,774.86
210502	Хоол, хүнс	567,000.00	3,567,374.86

Радио телевизийн үндэсний сүлжээ УТҮГ-ын 2025 оны санхүүгийн  
тайланд хийсэн аудитын тайлан

210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	44,711,900.00	2,706,400.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	491,673,490.07	254,163,793.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	75,061,950.00	5,448,200.00
210602	Тавилга	3,130,000.00	0
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	28,160,880.00	7,818,097.00
210604	Урсгал засвар	385,320,660.07	240,897,496.00
2107	Томилолт, зочны зардал	98,213,699.10	63,347,346.00
210701	Гадаад албан томилолт	23,096,329.10	0
210702	Дотоод албан томилолт	75,117,370.00	63,347,346.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	533,120,545.68	488,162,276.69
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	137,600,813.53	127,930,055.56
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	15,052,600.00	21,812,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	20,850,665.00	14,766,384.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	2,198,225.00	6,293,245.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	220,000.00	77,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	121,950,905.00	133,184,079.00
210807	Газрын төлбөр	234,355,105.00	183,122,037.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	892,232.15	977,476.13
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	14,900,000.00	4,420,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	14,900,000.00	4,420,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	231,740,664.00	167,774,003.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	231,740,664.00	167,774,003.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	155,591,197.00	31,104,000.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	0	79,036,301.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	66,622,467.00	56,843,702.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	9,527,000.00	790,000.00
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	22,990,021.06	-23,757,636.52
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН	190,587,813.00	0
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	190,587,813.00	0
2200	Дотоод эх үүсвэрээр	190,587,813.00	0
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	190,587,813.00	0
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	-190,587,813.00	0
25	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДАЛ	80,504.93	210,423.36
250001	Гадаад валютын ханшийн зөрүүний гарз	80,504.93	210,423.36
VII	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН	-80,504.93	-210,423.36
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	-167,678,296.87	-23,968,059.88
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	216,444,714.44	48,766,417.57
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	48,766,417.57	24,798,357.69

Радио телевизийн үндэсний сүлжээ УТҮГ-ын 2025 оны санхүүгийн  
тайланд хийсэн аудитын тайлан

**2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан**

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Дансны нэр, төрөл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
<b>1</b>	<b>НИЙТ ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН</b>	<b>6,369,000,000.00</b>	<b>6,330,566,528.94</b>	<b>40,228,160.14</b>	<b>99.40</b>
<b>12</b>	<b>Татварын бус орлого</b>	6,369,000,000.00	6,330,566,528.94	40,228,160.14	99.4
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	1,149,000,000.00	1,122,494,228.94	28,300,460.14	97.7
12004	Төсөв байгууллагын өөрийн орлого /үндсэн/	285,000,000.00	234,367,287.35	50,632,712.65	82.2
120010	Төсөв байгууллагын өөрийн орлого /туслах/	864,000,000.00	886,332,252.51	(22,332,252.51)	102.6
120009	бусад орлого /хүүгийн/		1,794,689.08		
122	Тусламжийн орлого	5,220,000,000.00	5,208,072,300.00	11,927,700.00	99.8
122001	Хандив тусламж /Улсын төсвөөс/	5,220,000,000.00	5,208,072,300.00	11,927,700.00	99.8
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>6,369,000,000.00</b>	<b>6,354,534,588.82</b>	<b>14,465,411.18</b>	<b>99.8</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	6,369,000,000.00	6,354,534,588.82	14,465,411.18	99.8
<b>210</b>	<b>БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	6,257,000,000.00	6,243,604,287.82	13,395,712.18	99.8
<b>2101</b>	<b>Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил</b>	4,198,000,000.00	4,197,482,887.92	517,112.08	100.0
210101	Үндсэн цалин	4,198,000,000.00	4,185,509,986.92	12,490,013.08	99.7
210105	Гэрээт ажлын цалин	-	11,972,901.00	(11,972,901.00)	
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	524,750,000.00	519,305,073.09	5,444,926.91	99.0
210201	Тэтгэврийн даатгал	355,780,750.00	351,519,812.54	4,260,937.46	98.8
210202	Тэтгэмжийн даатгал	42,351,750.00	42,231,713.38	120,036.62	99.7
210203	ҮОМШӨ-ний даатгал	23,132,800.00	22,068,982.30	1,063,817.70	95.4
210204	Ажилгүйдлийн даатгал	19,450,000.00	19,449,879.46	120.54	100.0
210205	Эрүүл мэндийн даатгал	84,034,700.00	84,034,685.41	14.59	100.0
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	575,545,000.00	573,646,258.65	1,898,741.35	99.7
210301	Гэрэл, цахилгаан	416,830,000.00	415,080,646.15	1,749,353.85	99.6
210302	Түлш, халаалт	117,500,000.00	117,407,994.00	92,006.00	99.9
210303	Цэвэр, бохир ус	40,800,000.00	40,745,218.50	54,781.50	99.9
210304	Байрны түрээс	415,000.00	412,400.00	2,600.00	99.4
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	137,320,000.00	136,802,877.61	517,122.39	99.6
210401	Бичиг хэрэг	5,520,000.00	5,515,352.00	4,648.00	99.9
210402	Тээвэр, шатахуун	80,600,000.00	80,548,424.00	51,576.00	99.9
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	33,500,000.00	33,481,173.61	18,826.39	99.9
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,200,000.00	1,200,000.00	-	100.0
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	16,500,000.00	16,057,928.00	442,072.00	97.3
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	6,400,000.00	6,273,774.86	126,225.14	98.0
210502	Хоол, хүнс	3,600,000.00	3,567,374.86	32,625.14	99.1
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	2,800,000.00	2,706,400.00	93,600.00	96.7
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	256,500,000.00	254,163,793.00	2,336,207.00	99.1

Радио телевизийн үндэсний сүлжээ УТҮГ-ын 2025 оны санхүүгийн  
тайланд хийсэн аудитын тайлан

210601	Багаж, техник, хэрэгсэл	5,500,000.00	5,448,200.00	51,800.00	99.1
210602	Тавилга	-	-	-	
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	8,000,000.00	7,818,097.00	181,903.00	97.7
210604	Урсгал засвар	243,000,000.00	240,897,496.00	2,102,504.00	99.1
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>65,000,000.00</b>	<b>63,347,346.00</b>	<b>1,652,654.00</b>	<b>97.5</b>
210701	Гадаад албан томилолт	-	-	-	
210702	Дотоод албан томилолт	65,000,000.00	63,347,346.00	1,652,654.00	97.5
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, Үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>488,985,000.00</b>	<b>488,162,276.69</b>	<b>822,723.31</b>	<b>99.8</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	128,000,000.00	127,930,055.56	69,944.44	99.9
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	21,815,000.00	21,812,000.00	3,000.00	100.0
210803	Даатгалын үйлчилгээ	15,000,000.00	14,766,384.00	233,616.00	98.4
210804	Тээврийн хэрэгслийн татвар	6,300,000.00	6,293,245.00	6,755.00	99.9
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	220,000.00	77,000.00	143,000.00	35.0
210806	Мэдээлэл, технологийн Үйлчилгээ	133,500,000.00	133,184,079.00	315,921.00	99.8
210807	Газрын төлбөр	183,150,000.00	183,122,037.00	27,963.00	100.0
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	1,000,000.00	977,476.13	22,523.87	97.7
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>4,500,000.00</b>	<b>4,420,000.00</b>	<b>80,000.00</b>	<b>98.2</b>
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	4,500,000.00	4,420,000.00	80,000.00	98.2
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>	
2132	Бусад урсгал шилжүүлэг	112,000,000.00	110,930,301.00	1,069,699.00	99.0
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	32,000,000.00	31,104,000.00	896,000.00	97.2
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	80,000,000.00	79,036,301.00	963,699.00	98.8
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал, урамшуулал	-	790,000.00	(790,000.00)	
8	ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН НИЙТ ТЭНЦЭЛ	-	(23,968,059.88)		
9	АЛДАГДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР		23,968,059.88		
7	Харилцах болон хадгаламжийн дансны цэвэр өөрчлөлт		23,968,059.88		
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний Үлдэгдэл	-	48,766,417.57		
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн Үлдэгдэл	-	24,798,357.69		
6	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ				
61	Байгууллагын тоо	1	1		
62	Ажилчдын тоо:Үүнээс	214	195	19	91.1
620001	Удирдах ажилтан	15	15	-	100.0
620002	Гүйцэтгэх ажилтан	166	150	16	90.4
620003	Үйлчлэх ажилтан	33	30	3	90.0

### **3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА**

#### **3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа**

“Радио телевизийн үндэсний сүлжээ” УТҮГ нь эрхэм зорилгоо “Шинэ дэвшилтэт технологийг ашиглан хэрэглэгчийн өнөөгийн болон ирээдүйн хэрэгцээг хагасан нийлмэл, орон зайнаас үл хамаарсан радио, телевизийн өргөн нэвтрүүлгийн үндэсний тоон технологийг сүлжээг өргөжүүлэх хөгжүүлнэ” гэж тодорхойлсон бөгөөд дараах үндсэн чиг үүргийг хэрэгжүүлж ажилласан байна. Тухайлбал:

- Улсын радио, телевизийн өргөн нэвтрүүлгийн дохиог улсын хэмжээнд дамжуулах, түгээх, хүлээн авах нөхцлийг бүрдүүлэх;
- Өргөн нэвтрүүлгийн радио, телевизийн дамжуулах сүлжээний ашиглалт, үйл ажиллагааг хэвийн, тасралтгүй, найдвартай хангах;
- Төр, засгийн бодлого, зайлшгүй шаардлагатай мэдээллийг бүх нийтэд шуурхай хүргэх техник, сүлжээний бэлэн байдлыг хангах;
- Мэргэжлийн боловсон хүчин бэлтгэх, техник, технологийн шинэчлэл хийх, өргөн нэвтрүүлгийн сүлжээний хөгжил, сайжруулалтыг хэрэгжүүлэх;
- Онцгой байдал, гамшгийн үед тусгайлсан дохио, анхааруулгыг бүх нийтийн сүлжээгээр дамжуулах;
- Өргөн нэвтрүүлгийн дохионы чанар, хүртээмжийг нэмэгдүүлэх зорилгоор дамжуулах станц, төхөөрөмж, тоног төхөөрөмжийн техникийн хяналт, ашиглалтыг хариуцах.

#### **3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин**

“Радио телевизийн үндэсний сүлжээ” УТҮГ нь үйл ажиллагаандаа Өргөн нэвтрүүлгийн тухай хууль, Харилцаа, холбооны тухай хууль, Радио долгионы тухай хууль, Төрийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль, Нийгмийн даатгалын тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Төрийн хэмнэлтийн тухай хууль, болон бусад хууль тогтоомжуудыг мөрдөн ажиллажээ.

Тайлант хугацаанд дараах хууль тогтоомж, бодлого чиглэлд өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль;
- Хувь хүний орлогын албан татварын тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай;
- Сангийн сайдын 2025 оны 01 сарын 03-ны өдрийн “Төсвийн байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам” А/03 дугаар тушаал;
- “Радио Телевизийн Үндэсний сүлжээ” УТҮГ-ын захирлын 2025 оны 09 дугаар сарын 30-ны өдрийн А/40 тушаалаар “Хөдөлмөрийн дотоод журам” шинэчлэн баталсан.

Удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөгүй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах шаардлагагүй гэж үзлээ.

#### **3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал**

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

“Радио телевизийн үндэсний сүлжээ” УТҮГ нь 2025 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

“Радио телевизийн үндэсний сүлжээ” УТҮГ нь Цахим хөгжил, харилцаа холбооны сайдын 2023 оны А/54 дугаар тушаалаар баталсан Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг нягтлан бодох бүртгэлд мөрдөж ажиллаж байна.

Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, -үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

### 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого ба толилуулгад орсон өөрчлөлт

“Радио телевизийн үндэсний сүлжээ” УТҮГ-ын 2025 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2025 оны А/03 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам”-ын дагуу бэлтгэжээ.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 1,575.7 сая төгрөгөөр буюу 2.0 хувиар буурсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	48,766.4	24,798.4	(23,968.0)
Авлага	85,474.6	88,033.8	2,559.2
Урьдчилгаа	450.0	1,521.0	1,071.0
Бараа материал	1,949,860.0	1,842,285.8	(107,574.2)
Үндсэн хөрөнгө	76,638,707.9	75,190,941.4	(1,447,766.5)
<b>Нийт хөрөнгө</b>	<b>78,723,258.9</b>	<b>77,147,580.4</b>	<b>(1,575,678.5)</b>
Өр төлбөр	10,496.8	2,105,865.2	2,095,368.4
Цэвэр хөрөнгө/өмчийн дүн	78,712,762.1	75,041,715.2	(3,671,046.9)
<b>Өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн</b>	<b>78,723,258.9</b>	<b>77,147,580.4</b>	<b>(1,575,678.5)</b>

Тайлант онд нөлөө бүхий өөрчлөлт гарсан мөнгөн хөрөнгө, бараа материал, үндсэн хөрөнгө, өр төлбөр, цэвэр хөрөнгө/өмчийн данснууд байна. Үүнд:

- Мөнгөн хөрөнгө дансны үлдэгдэл 24.8 сая төгрөг болж, 23.9 сая төгрөгөөр буурсан нь тайлант хугацааны үйл ажиллагааны зарцуулалттай холбоотой;
- Бараа материал дансны үлдэгдэл 1,842.3 сая төгрөг болж, 107.6 сая төгрөгөөр буурсан нь тайлант хугацаанд агуулахад байсан сэлбэг хэрэгсэлийг зарцуулсан нь нөлөөлсөн.
- Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 75,190.9 сая төгрөг болж, 1,447.8 сая төгрөгөөр буурчээ. Энэ нь тайлант онд 15.8 сая төгрөгийн хөрөнгийг өөрийн орлогоор, 40.9 сая төгрөгийн үнэтэй 2 ширхэг FM станцыг Цахим хөгжил инноваци, харилцаа холбооны яамны улсын төсвийн хөрөнгө оруулалтаар, 77.5 сая төгрөгийн тоног төхөөрөмжийг “Монголсат” ХХК-иас бартерийн гэрээгээр худалдаж авч Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын шийдвэрээр хөрөнгө акталж хассан зэрэг нь нөлөөлсөн.

Өр төлбөр дансны үлдэгдэл 2,105.8 сая төгрөг болж, 2,095.4 сая төгрөгөөр нэмэгдсэн нь 1,940.2 сая нь цахилгаан эрчим, усны төлбөр, 88.2 сая нь татварын өр, 67.0 сая нь бусад байгууллагуудад төлөх өр төлбөр тус тус өссөн нь голлон нөлөөлжээ. Цахилгаан эрчим хүчний салбарт төлөх өр төлбөр нэмэгдсэн гол шалтгаан нь цахилгаан эрчим хүчний үнэ нэмэгдсэн, улсын төсвөөс авах

санхүүжилт нь өмнөх оноос 392.2 сая төгрөгөөр, төсвийн саналаас 1,362.0 сая төгрөгөөр буурсантай холбоотой.

Цэвэр хөрөнгө/өмчийн дансны үлдэгдэл 75,041.7 сая төгрөг болж 3,671.1 сая төгрөгөөр буурсан нь тайлант үеийн үр дүнгээс шалтгаалсан.

Программ хангамжийн талаарх судалгаа авахад: Радио телевизийн үндэсний сүлжээ УТҮГ нь үйл ажиллагаандаа нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан гаргахад зориулагдсан Санхүүгийн тооцоолол ХХК-ийн Acolous санхүүгийн программ, Их тост уул ХХК-ийн телевизийн 16 суваг дамжуулах програм хангамжийн лицензийг ашиглаж байна. Эдгээр программууд нь хэвийн ажиллаж байгаа бөгөөд тайлант хугацаанд программын хөгжүүлэлт буюу лицензийн төлбөрт 4.0 сая төгрөг төлсөн байна.

### 3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### 3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2025 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 6,570.0 сая төгрөг, төсөвт байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлогоос 1,149.0 сая төгрөг, нэмэлт санхүүжилтээр 2,868.5 сая төгрөг, нийт 10,587.5 сая төгрөгийг бүрдүүлж, нийт зарлагыг 10,587.5 сая төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлжээ.

Төсвийн төслийн саналаас төсвийн санхүүжилтийг 1,350.0 сая төгрөгөөр бууруулж, нэмэлт санхүүжилтэд өгсөн 2,868.6 сая төгрөгийн саналыг хасч төсвийг 5,220.0 сая төгрөгөөр баталсан байна.

#### 3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 5,208.1 сая, үйл ажиллагааны орлогоос 1,122.5 сая нийт 6,330.6 сая төгрөгийн орлогыг бүрдүүлжээ.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 6,354.5 сая төгрөг буюу 99.7 хувийн гүйцэтгэлтэй гарсан байна.

*Хүснэгт 2.Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл*

*/Мянган төгрөгөөр/*

Д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
1	<b>71301 Нийт урсгал зардал</b>	<b>6,369,000.0</b>	<b>6,354,534.6</b>	<b>14,465.5</b>	99.7
2	80101 Бараа үйлчилгээний зардал	6,257,000.0	6,243,604.3	13,395.7	99.7
3	80802 Бусад урсгал шилжүүлэг	112,000.0	110,930.3	1,069.7	99.0

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан “Төрийн аудитын байгууллагаас төсвийн тухай хуулийн дагуу 2025-2026 онд гүйцэтгэх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн аудитад баримтлах ерөнхий чиглэл”-ийн дагуу шалгагдагч байгууллагаас 6 төрлийн судалгаа авч үр дүнг тайланд тусгалаа. Үүнд:

- Байгууллагын орон тооны цомхотгол: “Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хууль баталсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын 54 дүгээр тогтоолын 1 дэх хэсэгт заасныг хэрэгжүүлж, төсөвт байгууллагын үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлэх, чиг үүргийн давхардлыг арилгаж оновчтой болгох, төрийн үйлчилгээг цахим болгох ажлыг эрчимжүүлэх, ажлын ачааллыг нягтруулах, бүтээмжийг дээшлүүлэх зорилгоор “Монгол Улсын хөгжлийн 2026 оны төлөвлөгөө”-нд туссан багш, эмч нараас бусад төрийн албан хаагчийг орон тоог 9 хувиар бууруулах арга хэмжээг 2025 онд эхлүүлсэн. Тус байгууллагын батлагдсан орон тоо 228 байсныг үйлчилгээний чиг үүргийн ажлын байрны тоог бууруулахгүйгээр цомхотгох боломжтой сул ажлын байрны 5, захиргааны 6, үйлчилгээний 2 ажилтаныг цомхотгол хийж 214 орон тоотой ажиллахаар шинэчлэн баталсан.
- Радио телевизийн үндэсний сүлжээ УТҮГ-ын гүйцэтгэх захирлын 2025 оны А/37 дугаар тушаалаар албан хаагчдын ажлын нэг өдрийн хоолны мөнгийг 23.0 мянган төгрөгөөр, унааны төлбөрийг 2.0 мянган төгрөгөөр баталсан байна. Тайлант онд унаа хоолны хөнгөлөлтийн зардалд 221.9 сая төгрөгийг төлөвлөснөөс тайлант хугацаанд 216.2 сая төгрөгийг зарцуулж, 5.8 сая төгрөгийг хэмнэжээ.
- Сургалтанд салбарын ажилчдыг хамруулж 4.4 сая мянган төгрөгийг зарцуулсан;
- Радио телевизийн үндэсний сүлжээ УТҮГ-т төрд учирсан хохирлыг барагдуулахтай холбоотой гарсан зардал гараагүй болно.

### 3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант хугацаанд нэмэлт санхүүжилт аваагүй болно.

### 3.6 Худалдан авах ажиллагаа

“Радио телевизийн үндэсний сүлжээ” УТҮГ-ын захирлын 2025 оны 5 дугаар сарын 30-ны өдрийн А/26 тушаалаар тайлант оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг баталсан байна. Төлөвлөгөөнд 5 нэр төрлийн 143.5 сая төгрөгийн хангамжийн бараа материал, 11 төрлийн 313.2 сая төгрөгийн багаж техник, 282.5 сая төгрөгийн бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээ, нийт 739.2 сая төгрөгийн худалдан авалт хийхээр төлөвлөсөн байна. Их чадлын ламп, станцын сэлбэг хэрэгсэлийн 2 худалдан авалтыг харьцуулалтын аргаар сонгон шалгаруулалт явуулах, бусдыг нь шууд худалдан авалтын аргыг сонгохоор төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр 90.0 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий их чадлын ламп худалдаж авах тендерийг 3 удаа зарлаж 1 оролцогч ирсэн нь шаардлага хангаагүй, 49.7 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий станцын сэлбэг худалдаж авах тендерийг 3 удаа зарласан боловч оролцогч ирээгүйгээс худалдан авалт хийгдээгүй байна. Бусад худалдан авалтуудын гүйцэтгэл 70 гаруй хувьтай байгаа нь санхүү төлбөрийн асуудалтай холбоотойгоор хийгдээгүй байна.

“Радио телевизийн үндэсний сүлжээ” УТҮГ-ын захиргаа, ажилтны үйлдвэрчний эвлэлийн хороо нь 2025 оны 5 дугаар сарын 21-ний өдөр 2024-2026 онд хэрэгжүүлэх хамтын гэрээг байгуулсан.

## **4. АУДИТЫН ТАЙЛАН**

### **4.1 Ерөнхий зүйл**

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Радио телевизийн үндэсний сүлжээ УТҮГ-ын оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланд хийсэн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийсэн “Радио телевизийн үндэсний сүлжээ” УТҮГ, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн компанийн үйл ажиллагааг сайжруулах ажил татварын цахим системд борлуулалтын орлогыг тухай бүр оруулахтай холбоотой өгсөн зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг “Ажу мэргэн аудит” ХХК-ийн аудитор Д.Наранчимэг, туслах аудитор Ж.Золжаргал нар гүйцэтгэж, аудитын чанарын хяналтын менежер Л.Долгорсүрэн, захирал Л.Насанбуян нар анхан шатны чанарын хяналтыг, Санхүүгийн аудитын газрын аудитор Д.Номингуа, аудитын менежер А.Цогбаяр, газрын захирал, тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг нар дараагийн шатны хяналтыг тус тус хэрэгжүүлсэн.

“Радио телевизийн үндэсний сүлжээ” УТҮГ нь 2025 оны санхүүгийн тайлангаа Үндэсний аудитын газарт 2026 оны 2 дугаар сарын 16-ны өдрийн 01/66 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

### **4.2 Материаллаг байдал**

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2024 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “Дунд” гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2024 оны жилийн эцсийн санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт орлого 10,248.9 сая төгрөгөөс 1.0 хувиар буюу 102.5 сая төгрөгөөр, тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

### **4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт**

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор болон тайлант хугацааны санжүүжилт хүрэлцэхгүй байсан тул өөрсдийн нөөц боломжоор тэвчиж болох зардлуудыг хэмнэж ажилласаны үр дүнд бараа үйлчилгээний зардлыг 13.4 сая төгрөгөөр дутуу зарцуулсан байна.

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтээр горим сорил хэрэгжүүлэхэд тус хуулийн хязгаарласан заалтуудтай холбоотой зөрчил илрээгүй болно.

### **4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

#### 4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст 2025 онд ил тод байршуулбал зохих нийт 156 мэдээллийг байршуулж хуулийг хэрэгжүүлж ажилласан байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн хүрээнд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай болон бусад хууль тогтоомжийн хүрээнд шалгасан зүйлийг холбогдох шалгуурт нийцсэн гэж дүгнэлээ.

#### 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

##### 4.5.1 Завсрын аудитын талаар

Завсрын аудитаар шалгагдагч байгууллагын 2025 оны 2 дугаар улирлын санхүүгийн тайланг хамруулж авлага, өглөг, мөнгөн хөрөнгө, үндсэн хөрөнгө, цалин, орлого, зарлагын данснуудын хувьд горим, сорил хэрэгжүүлсэн.

Аудитын илрүүлэлтийг шалгагдагч байгууллагад танилцуулж, асуудлын бүртгэлээр баталгаажуулсан. Завсрын аудитаар хэрэгжүүлсэн горим сорилын үр дүнд нийт 108.3 сая төгрөгийн 4 алдаа зөрчил илэрснээс жилийн эцсийн санхүүгийн тайлангийн аудитаар дахин хянахад 28.8 сая төгрөгийн 2 алдааг залруулсан, 79.5 сая төгрөгийн 2 зөрчлийг аудитын тайланд тусгасан болно.

##### 4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн 108.6 сая төгрөгийн зөрчил 15.5 сая төгрөгийн 2 төлбөрийн акт, 12.1 сая төгрөгийн зөрчилд 1 албан шаардлага, 81.0 сая төгрөгийн зөрчилд 5 зөвлөмж өгснөөс аудитын шийдвэрийн хэрэгжилт 91.1 хувьтай байна.

Хүснэгт 3. Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/сая төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитаар өгсөн		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт	2	15.5	2	15.5	100.0
Албан шаардлага	2	115.1	3	115.1	100.0
Зөвлөмж	7	214.9	5	157.7	73.3
<b>Нийт дүн</b>	<b>11</b>	<b>345.5</b>	<b>11</b>	<b>234.7</b>	<b>91.1</b>

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн 57.1 сая төгрөгийн 2 зөвлөмжийг биелүүлээгүй, зөрчлийг давтан гаргасан тул албан шаардлага өгсөн.

#### 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Тус төвийн бүтэц орон тоо, үйл ажиллагааг нэгтгэж санхүү, нягтлан бодох бүртгэлтэй холбоотой үйл ажиллагааг Радио телевизийн үндэсний сүлжээ УТҮГ-т нэгтгэсэн гэсэн боловч нэгтгэх үйл явцтай холбоотой албан ёсны шийдвэр гараагүй, хаалтын баланс гаргаж нэгтгээгүй байна. 2026 онд хаалтын баланс гаргахтай холбоотойгоор бүртгэлээр тавих хяналт дээр анхаарах шаардлагатай.

### 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 287.2 сая төгрөгийн зөрчил<sup>1</sup> илэрснээс 3.6 сая төгрөгийн 1 төлбөрийн акт тогтоож, 271.7 сая төгрөгийн 4 албан шаардлага хүргүүлж, 11.9 сая төгрөгийн 1 зөвлөмж өгсөн.

Нийт илрүүлсэн алдаа, зөрчлөөс 287.2 сая төгрөгийн залруулагдаагүй зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс 184.7 сая төгрөгөөр их тул “Хязгаарлалттай” дүгнэлт өглөө.

#### 5.1 Төлбөрийн акт

Тайлант онд 38 ажилтан, албан тушаалтанд хөдөө орон нутагт албан томилолтоор ажилласан хугацааны албан томилолтын зардалтай давхардуулан 3.6 сая төгрөгийн хоол, унааны хөнгөлөлт олгосон.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1-д “Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ.”, 20 дугаар зүйлийн 20.2.5-д “дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах;”, Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, 16.5.2 “батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих” Засгийн газрын 2019 оны 6 дугаар тогтоолоор баталсан Төрийн албан хаагчид нөхөн төлбөр олгох журмын 2.2-т Албан томилолтоор ажиллах үеийн нөхөх төлбөр дараахь зардлаас бүрдэнэ: “ 2.2.1-д унааны зардал, 2.2.2-т байрны зардал, 2.2.3-т хоолны зардал” гэж тус тус заасантай нийцээгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Давхардуулан бодож олгосон унаа, хоолны хөнгөлөлтийг буруутай албан тушаалтнаар нөхөн төлүүлэх төлбөрийн акт тогтоов.

#### 5.2 Албан шаардлага

1. Өмнөх онуудад үүссэн 14 харилцагчтай холбоотой 12.1 сая төгрөгийн авлагыг барагдуулах арга хэмжээ аваагүй, өмнөх оны аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлээгүй байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 67 дугаар зүйлийн 1-д “Төрийн өмчит хуулийн этгээдийн эрх баригч нь өмч хөрөнгийн хадгалалт, хамгаалалтын байдалд өдөр тутам тавих дотоодын хяналтыг зохион байгуулж, түүний үр дүнг төрийн өмнө хариуцна”, “Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль”-ийн 20 дугаар зүйл “Ерөнхий нягтлан бодогчийн үүрэг”: 20.2.5 “дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах” гэсэн заалттай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Өмнөх онуудад үүссэн авлагыг барагдуулаагүй, аудитын өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлээгүй зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлэв.

<sup>1</sup> Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

2. Анхан шатны баримтын бүрдэл дутуу, төлбөрийн баримтаар баталгаажуулаагүй нийт 118.2 сая төгрөгийн бараа материал, үндсэн хөрөнгийг санхүүгийн тайланд хүлээн зөвшөөрч бүртгэсэн нь өмнөх оны аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлээгүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.1-д "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно", 13.4-т "Аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, нягтлан бодогч нь үйлдвэрлэл, үйлчилгээний шат дамжлага, аж ахуйн үйл ажиллагааны хүрээнд гарсан хөрөнгө, эх үүсвэрийн хөдлөл, өөрчлөлт бүрийг анхан шатны баримтад бичгээр болон цахимаар бичилт хийж баталгаажуулна", 13.7-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно" гэсэн заалтуудтай тус тус нийцэхгүй байна.

**Шийдвэрлэсэн нь:** Анхан шатны баримтын бүрдэл дутуу бараа материал, үндсэн хөрөнгийг тайланд хүлээн зөвшөөрч бүртгэсэн, өмнөх оны аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлээгүй зөрчлийг таслан зогсоох албан шаардлага хүргүүлэв.

3. Цахим хөгжил, инноваци, харилцаа холбооны сайдын 2025 оны 01/1423 дугаартай харьяа байгууллагын удирдлага нарт чиглэл хүргүүлэх тухай албан бичиг болон газрын захирлын 2025 оны Б/118 дугаар тушаалыг үндэслэн албан хаагчдын ажлын үр дүнг үнэлсэн шалгуур үзүүлэлт нь тодорхойгүй байхад 63.9 сая төгрөгийн урамшуулалыг олгосон байна.

Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1-д "Хэмнэлтийн горим хэрэгжүүлэхэд дараах зарчмыг баримтална:", 4.1.6-д "сахилга баттай байх", 15 дугаар зүйлийн 15.1.3-т "хууль тогтоомжид зааснаас өөр хэлбэрээр тэтгэмж, шагнал, урамшуулал, дэмжлэг олгох" Засгийн газрын 2019 оны 01 дүгээр сарын 09-ний өдрийн 5 дугаар тогтоолын хавсралтаар баталсан "төрийн албан хаагчид мөнгөн урамшуулал олгож журам"-ын 1.2.1-т "төсвийн ерөнхийлөн захирагч нь харьяа байгууллагын гүйцэтгэлийн үнэлгээ, ажлын үр дүнг үндэслэн холбогдох гүйцэтгэлийн үнэлгээний журамд тодорхойлсон мөнгөн урамшуулал авах нөхцөлийг хангасан төсвийн төвлөрүүлэн захирагч болон төсвийн шууд захирагчид урамшуулал олгож болно" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

**Шийдвэрлэсэн нь:** Ажилтнуудад ажлын үр дүнг үнэлсэн шалгуур үзүүлэлт нь тодорхойгүй, урамшуулал олгосон зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлэв.

4. "Монголсат нетворкс" ХХК-тай "Ажил гүйцэтгэх гэрээ" байгуулж, гэрээний дагуу төлөгдөх ажил, үйлчилгээний төлбөрөөс тайлант оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдаагүй, 15 ширхэг 49.1 сая төгрөгийн суурин компьютер, 5 ширхэг 28.4 сая төгрөгийн зөөврийн компьютерийг бартерийн хэлбэрээр худалдан авалт хийсэн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 44 дүгээр зүйлийн 44.1.Захиалагч батлагдсан төсөвт туссан төсөл, арга хэмжээ бүрээр худалдан авах ажиллагааг үр ашигтай төлөвлөж, батална" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

**Шийдвэрлэсэн нь:** Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдаагүй үндсэн хөрөнгийг бартераар худалдан авсан зөрчлийг таслан зогсоох албан шаардлага хүргүүлэв.

### 5.3 Зөвлөмж

#### 1. Зардалтай холбоотой асуудал

Илрүүлэлт: Ажил үйлчилгээний орлогыг цахим төлбөрийн баримтын системд тухай бүр бүртгэж тайлагнаагүй, борлуулалтын төлбөрийн баримт, нэхэмжлэхийг цаг хугацаанд нь үнэн зөв мэдээллэхгүйгээр улирлын эцэст бөөн дүнгээр бүртгэсний улмаас орлогын дүнг 11.9 сая төгрөгийн зөрүүтэй илэрхийлсэн байна.

Энэ нь Татварын ерөнхий хуулийн 28 дугаар зүйлийн 28.5-д "Татвар төлөгч борлуулалт хийх тухай бүрд хэрэглэгчийн системээс дахин давтагдашгүй дугаар бүхий төлбөрийн баримтыг хэвлэж өгөх, эсхүл цахимаар илгээх үүрэгтэй", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д "Аж ахуйн нэгж, байгууллага нягтлан бодох бүртгэлийн дараах зарчмыг баримтална", 5.1.3-т "жинхэнэ хэрэгжилтийн", 20 дугаар зүйлийн 20.2.3-т "холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 5 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Ажил үйлчилгээ үзүүлж орлого бүртгэсэн тухай бүр татварын цахим системд төлбөрийн баримт, нэхэмжлэхийг оруулж байх, холбогдох хуулийн заалтуудыг хэрэгжүүлж, зөрчлийг давтан гаргахгүй байх.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Төрийн аудитын байгууллагад 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

### Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		/мянган төгрөгөөр/										
			Үүнээс										
	Тоо	Дүн	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал		
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Өмнөх онуудад үүссэн 14 харилцагчтай холбоотой 12,081.8 мянган төгрөгийн авлагыг барагдуулах арга хэмжээ аваагүй, өмнөх оны аудитаар өгсөн зөвлөмжийг биелүүлээгүй.	1	12,081.9			1	12,081.9							
Албан томилолтоор хөдөө орон нутагт ажилласан ажилтнуудад нийт 3,585.0 мянган төгрөгийн хоол, унааны хөнгөлөлтийг албан томилолтоор ажиллах үеийн нөхөх төлбөртэй давхардуулан олгосон.	1	3,585.0	1	3,585.0									
Тайанлт оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдаагүй "Монголсат нетворкс" ХХК-тай байгуулсан гэрээний дагуу төлөгдөх ажил, үйлчилгээний төлбөрөөс 49,170.0 мянган төгрөгийн суурин компьютер, 28,380.0 мянган төгрөгийн зөөврийн компьютерийг үнийг суутган тооцуулж, бартераар худалдаж авсан.	1	77,550.0			1	77,550.0							
Ажил үйлчилгээний орлогыг цахим төлбөрийн баримтын системд тухай бүр бүртгэж тайлагнаагүй, борлуулалтын төлбөрийн баримт, нэхэмжлэхийг цаг хугацаанд нь үнэн зөв мэдээллэхгүйгээр улирлын эцэст бөөн дүнгээр бүртгэснээс орлогын дүнг 11,901.4 мянган төгрөгийн зөрүүтэй илэрхийлсэн.	1	11,901.4					1	11,901.4					
Анхан шатны баримтын бүрдэл дутуу, төлбөрийн баримтаар баталгаажаагүй бараа материал, үндсэн хөрөнгийг санхүүгийн тайланд хүлээн зөвшөөрч бүртгэсэн нь өмнөх оны аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлээгүй.	1	118,193.3			1	118,193.3							
Цахим хөгжил, инноваци, харилцаа холбооны сайдын 2025 оны 01/1423 дугаартай харьяа байгууллагын удирдлага нарт чиглэл хүргүүлэх тухай албан бичиг болон байгууллагын захирлын 2025 оны Б/118 дугаар тушаалын дагуу албан хаагчдад олгосон 63,924.0 мянган төгрөгийн урамшууллыг сар бүрийн үр дүнгийн нэмэгдэлтэй давхардуулан олгосон.	1	63,924.00			1	63,924.0							
<b>Дүн</b>	<b>6</b>	<b>287,235.6</b>	<b>1</b>	<b>3,585.0</b>		<b>271,749.2</b>	<b>1</b>	<b>11,901.4</b>					



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР  
АКТ

2026 оны 03 сарын 16 өдөр

Дугаар 153/А0150169

Улаанбаатар хот

САГ-2026/58/НА-СТА-ТӨҮГ

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Радио телевизийн үндэсний сүлжээ УТҮГ-ын 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Нэр бүхий 38 ажилтан, албан тушаалтанд хөдөө орон нутагт албан томилолтоор ажилласан хугацааны томилолтын зардалтай давхардуулан 3,585,000.00 /Гурван сая таван зуун наян таван мянган/ төгрөгийн хоол, унааны хөнгөлөлт олгосон.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1-д "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ.", 20 дугаар зүйлийн 20.2.5-д "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах;", Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 16.5.2 "батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих" Засгийн газрын 2019 оны 6 дугаар тогтоолоор баталсан Төрийн албан хаагчид нөхөн төлбөр олгох журмын 2.2-т Албан томилолтоор ажиллах үеийн нөхөх төлбөр дараах зардлаас бүрдэнэ: "2.2.1-д унааны зардал, 2.2.2-т байрны зардал, 2.2.3-т хоолны зардал" гэж тус тус заасантай нийцээгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2 "Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.3 "цалин хөлс, шагнал, урамшуулал, тэтгэмжийг зөрүүтэй тооцож олгосон" гэж заасныг тус тус үндэслэн **ТОГТООХ нь:**

1. Давхардуулан олгосон хоол, унааны хөнгөлөлтийн 3,585,000.00 /Гурван сая таван зуун наян таван мянган/ төгрөгийг цалин хөлс хариуцсан нягтлан бодогч /Б.Ариун/, Ерөнхий нягтлан бодогч /Б.Болормаа/ нараар нөхөн төлүүлж, Үндэсний аудитын газрын Төрийн сан дахь Аудитын шалгалтын орлогын 100900000601 тоот дансанд төвлөрүүлэх;
2. Актын биелэлтийг 2026 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Радио телевизийн үндэсний сүлжээ УТҮГ-ын захирал /Ц.Пүрэвням/-д хариуцуулав.

АКТ ТОГТООСОН:

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН  
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  
АУДИТЫН МЕНЕЖЕР  
АЖУ МЭРГЭН АУДИТ ХХК-ИЙН ЗАХИРАЛ



Ц.НАРАНЧИМЭГ  
А.ЦОГБАЯР  
Л.НАСАНБУЯН



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 03 сарын 16 өдөр

Дугаар 662/А0150169

Улаанбаатар хот

САГ - 2026/58/НА - СТА - ТӨҮГ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Радио телевизийн үндэсний сүлжээ УТҮГ-ын 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Өмнөх онуудад үүссэн 14 харилцагчтай холбоотой 12,081,869.00 /арван хоёр сая наян нэгэн мянга найман зуун жаран есөн/ төгрөгийн авлагыг барагдуулах арга хэмжээ авч ажиллаагүй, өмнөх оны аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлээгүй.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 67 дугаар зүйлийн 1-д "Төрийн өмчит хуулийн этгээдийн эрх баригч нь өмч хөрөнгийн хадгалалт, хамгаалалтын байдалд өдөр тутам тавих дотоодын хяналтыг зохион байгуулж, түүний үр дүнг төрийн өмнө хариуцна", "Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль"-ийн 20 дугаар зүйлийн 20.2.5 "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах" гэсэн заалттай тус тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1.10 "аудитаар илэрсэн алдаа, зөрчил, түүнийг арилгахаар өгсөн зөвлөмжийг хугацаанд нь хэрэгжүүлээгүй бол" гэж заасныг тус тус үндэслэн **ШААРДАХ** нь:

- 1 Өмнөх онуудад үүссэн авлагыг барагдуулаагүй, өмнөх оны аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлээгүй зөрчлийг арилгаж, биелэлтийг 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
- 2 Цаашид, алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Радио телевизийн үндэсний сүлжээ УТҮГ-ын захирал /Ц.Пүрэвням/, ерөнхий нягтлан бодогч /Б.Болормаа/ нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН  
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  
АУДИТЫН МЕНЕЖЕР  
АЖУ МЭРГЭН АУДИТ ХХК-ИЙН ЗАХИРАЛ



Ц.НАРАНЧИМЭГ  
А.ЦОГБАЯР  
Л.НАСАНБУЯН



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 03 сарын 16 өдөр

Дугаар 663/А0150169

Улаанбаатар хот

САГ-2026/58/НА - СТА - ТӨҮГ

Зөрчил таслан зогсоох тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Радио телевизийн үндэсний сүлжээ УТҮГ-ын 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Анхан шатны баримтын бүрдэл дутуу, төлбөрийн баримтаар баталгаажуулж 118,193,295.00 /нэг зуун арван найман сая нэг зуун ерэн гурван мянга хоёр зуун ерэн таван/ төгрөгийн бараа материал, үндсэн хөрөнгийг санхүүгийн тайланд хүлээн зөвшөөрч бүртгэсэн, өмнөх оны аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлээгүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-д "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно", 13.4-т "Аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, нягтлан бодогч нь үйлдвэрлэл, үйлчилгээний шат дамжлага, аж ахуйн үйл ажиллагааны хүрээнд гарсан хөрөнгө, эх үүсвэрийн хөдлөл, өөрчлөлт бүрийг анхан шатны баримтад бичгээр болон цахимаар бичилт хийж баталгаажуулна", 13.7-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно" гэсэн заалтуудтай тус тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1.10 "аудитаар илэрсэн алдаа, зөрчил, түүнийг арилгахаар өгсөн зөвлөмжийг хугацаанд нь хэрэгжүүлээгүй бол" гэж заасныг тус тус үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Анхан шатны баримтын бүрдэл дутуу бараа материал, үндсэн хөрөнгийг тайланд хүлээн зөвшөөрч бүртгэсэн, өмнөх оны аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлээгүй зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид, алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Радио телевизийн үндэсний сүлжээ УТҮГ-ын захирал /Ц.Пүрэвням/, ерөнхий нягтлан бодогч /Б.Болормаа/ нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН  
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  
АУДИТЫН МЕНЕЖЕР  
АЖУ МЭРГЭН АУДИТ ХХК-ИЙН ЗАХИРАЛ



Ц.НАРАНЧИМЭГ  
А.ЦОГБАЯР  
Л.НАСАНБУЯН



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 03 сарын 16 өдөр

Дугаар 664/А0150169

Улаанбаатар хот

САГ-2026/58/НА - СТА-ТӨҮГ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Радио телевизийн үндэсний сүлжээ УТҮГ-ын 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Цахим хөгжил, инноваци, харилцаа холбооны сайдын 2025 оны 01/1423 дугаартай харьяа байгууллагын удирдлага нарт чиглэл хүргүүлэх тухай албан бичиг болон газрын захирлын 2025 оны 06 дугаар сарын 18-ны өдрийн Б/118 дугаар тушаалыг үндэслэн албан хаагчдын ажлын үр дүнг үнэлсэн шалгуур үзүүлэлт нь тодорхойгүй байхад 63,924,000.00 /жаран гурван сая есөн зуун хорин дөрвөн мянган/ төгрөгийн урамшууллыг олгосон байна.

Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1-т "Хэмнэлтийн горим хэрэгжүүлэхэд дараах зарчмыг баримтална:", 4.1.6-д "сахилга баттай байх", 15 дугаар зүйлийн 15.1.3-т "хууль тогтоомжид зааснаас өөр хэлбэрээр тэтгэмж, шагнал, урамшуулал, дэмжлэг олгох", Засгийн газрын 2019 оны 01 дүгээр сарын 09-ний өдрийн 5 дугаар тогтоолын хавсралтаар баталсан "Төрийн албан хаагчид мөнгөн урамшуулал олгож журам"-ын 1.2.1-т "төсвийн ерөнхийлөн захирагч нь харьяа байгууллагын гүйцэтгэлийн үнэлгээ, ажлын үр дүнг үндэслэн холбогдох гүйцэтгэлийн үнэлгээний журамд тодорхойлсон мөнгөн урамшуулал авах нөхцөлийг хангасан төсвийн төвлөрүүлэн захирагч болон төсвийн шууд захирагчид урамшуулал олгож болно" гэж заасантай тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1.11-д "Хууль тогтоомж, гэрээ хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал" гэж заасныг тус тус үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Ажилтнуудад ажлын үр дүнг үнэлсэн шалгуур үзүүлэлт нь тодорхойгүй байхад урамшуулал олгосон зөрчлийг арилгаж, биелэлтийг 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид, алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Радио телевизийн үндэсний сүлжээ УТҮГ-ын захирал /Ц.Пүрэвням/, ерөнхий нягтлан бодогч /Б.Болормаа/ нарт даалгав.

**АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:**

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН  
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  
АУДИТЫН МЕНЕЖЕР  
АЖУ МЭРГЭН АУДИТ ХХК-ИЙН ЗАХИРАЛ



Ц.НАРАНЧИМЭГ  
А.ЦОГБАЯР  
Л.НАСАНБУЯН

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-264230

ATA14957  
9025381411

Z:\Alban Shaardlaga\2026\0316 SAG-22.Docx

1526180789



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 03 сарын 16 өдөр

Дугаар 665/А0150169

Улаанбаатар хот

САГ-2026/58/НА-СТА-ТӨҮГ

Зөрчил таслан зогсоох тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Радио телевизийн үндэсний сүлжээ УТҮГ-ын 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

"Монголсат нетворкс" ХХК-тай "Ажил гүйцэтгэх гэрээ" байгуулж, гэрээний дагуу төлөгдөх ажил, үйлчилгээний төлбөрөөс тайлант оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдаагүй 15 ширхэг 49,170,000.00 /дөчин есөн сая нэг зуун далан мянган/ төгрөгийн суурин компьютер, 5 ширхэг 28,380,000.00 /хорин найман сая гурван зуун наян мянган/ төгрөгийн зөөврийн компьютерыг бартерын хэлбэрээр худалдан авалт хийсэн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 44 дүгээр зүйлийн 44.1-д "Захиалагч батлагдсан төсөвт туссан төсөл, арга хэмжээ бүрээр худалдан авах ажиллагааг үр ашигтай төлөвлөж, батална." гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1.11-д "Хууль тогтоомж, гэрээ хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал" гэж заасныг тус тус үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдаагүй үндсэн хөрөнгийг худалдан авдаг зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид, алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Радио телевизийн үндэсний сүлжээ УТҮГ-ын захирал /Ц.Пүрэвням/, ерөнхий нягтлан бодогч /Б.Болормаа/ нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН  
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  
АУДИТЫН МЕНЕЖЕР  
АЖУ МЭРГЭН АУДИТ ХХК-ИЙН ЗАХИРАЛ



Ц.НАРАНЧИМЭГ  
А.ЦОГБАЯР  
Л.НАСАНБУЯН

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-264230

Z: Alban Shaardlaga 2026/0316.SAG-22.Docx

1526180791